МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 4 дүгээр улирал

Улаанбаатар
2020



## 1. Төлбөрийн тэнцэл

Урсгал ба хөрөнгийн данс 2019 оны 4 дүгээр улиралд 788 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,052 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 189 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -75 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 3 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 28 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 4,349 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 9.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

*Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)*




### Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2%-иар буурч 3,079 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 29 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, зэсийн экспорт 150 сая ам.доллараар (29%), чулуун нүүрс 24 сая ам.доллараар (4%), жонш 24 сая ам.доллараар (32%) тус тус буурсан бол СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 61 сая ам.доллараар (10%), нефтийн бүтээгдэхүүний импорт 10 сая ам.доллараар (3%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 58 сая ам.доллараар буурчээ.

*Дүрслэл 2. Барааны худалдаа (сая ам.доллар)*




### Үйлчилгээний худалдаа

2019 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 21%-иар буюу 136 сая ам.доллараар буурч, 499 сая ам.долларт хүрсэн. Үүнд бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 114 сая ам.доллар, тээврийн үйлчилгээний алдагдал 63 сая ам.доллар, барилгын үйлчилгээний алдагдал 50 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна *(Дүрслэл 3)*.

*Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа (сая ам.доллар)*




Үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 30%-иар буюу 67 сая ам.доллараар өсч 292 сая ам.долларт хүрчээ. Үүний 39% буюу 115 сая ам.долларыг тээвэр, 23% буюу 66 сая ам.долларыг аялал жуулчлал, 28% буюу 81 сая ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээний экспортын орлого бүрдүүлж байна.

*Дүрслэл 4. Үйлчилгээний экспорт (сая ам.доллар)*



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний импорт 8%-иар буюу 68 сая ам.доллараар буурч, 790 сая ам.долларт хүрсэн ба үүнээс 32%-ийг буюу 256 сая ам.долларыг аялал жуулчлал, 27%-ийг буюу 213 сая ам.долларыг тээвэр, 19%-ийг буюу 147 сая ам.долларыг бусад, 13%-ийг буюу 103 сая ам.долларыг санхүүгийн үйлчилгээ авахад тус тус зарцуулжээ.

*Дүрслэл 5. Үйлчилгээний импорт (сая ам.доллар)*




### *Аялал жуулчлалын үйлчилгээ*

Сүүлийн 3 жилийн дунджаар аялал жуулчлалын үйлчилгээний дансны орлого нь манай улсын нийт үйлчилгээний экспортын 39%-ийг, зарлага нь нийт үйлчилгээний импортын 28%-ийг бүрдүүлсэн байна.

Тэгвэл аялал жуулчлалын үйлчилгээний салбарын орлогын 21%-ийг БНСУ, 19%-ийг БНХАУ, 12%-ийг ОХУ, 5%-ийг Япон, 33%-ийг бусад улсын аялагчдад үзүүлсэн үйлчилгээнээс хүлээн авсан байна.

*Дүрслэл 6. Аялалын үйлчилгээний экспорт, 2017-2019 (сая ам.доллар)*




Харин аялал жуулчлалын салбарын импортыг улсаар нь ангилбал: Монгол улсын иргэд нийт зардлын 20%-ийг Япон, 17%-ийг БНСУ, 8%-ийг ОХУ, 8%-ийг Герман, 5%-ийг БНХАУ-д аялахдаа зарцуулсан байна.

*Дүрслэл 7. Аялалын үйлчилгээний импорт, 2017-2019 (сая ам.доллар)*




## Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 415 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 17%-иар буюу 62 сая ам.доллараар өссөн үзүүлэлтэй байна. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал голчлон нөлөөлсөн. Тайлант улиралд манай улс гадаад бонд, үнэт цаасны хүүгийн төлбөрт 102 сая ам.доллар, ногдол ашигт 71 сая ам.доллар, шууд хөрөнгө оруулагчийн зээлийн хүүгийн төлбөрт 128 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 164 сая ам.доллар, харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 3 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

*Дүрслэл 8. Анхдагч орлого (сая ам.доллар)*




## Хоёрдогч орлого

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2019 оны 4 дүгээр улиралд Монгол улс нийт 50 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 20 сая ам.доллараар бага орлого

хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 3%-иар өссөн, харин гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 4%-иар буурсан байна.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 22 сая ам.доллараар буурсан байна.

*Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2019,IV улирал (мян ам.доллар)*

| | Хүлээн авсан | | | Шилжүүлсэн | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Хувь | Өсөлт | Дүн | Хувь | Өсөлт |
| **Солонгос** | 29,972 | 43% ▼ | -18% | 2,715 | 9% ▲ | 8% |
| **Америк** | 3,159 | 5% ▼ | -72% | 4,635 | 16% ▲ | 10% |
| **Хятад** | 294 | 0% ▼ | -58% | 1,080 | 4% ▲ | 3% |
| **Гонг Конг** | 631 | 1% ▼ | -5% | 239 | 1% ▼ | -23% |
| **Англи** | 1,106 | 2% ▲ | 67% | 1,489 | 5% ▼ | -18% |
| **ОХУ** | 10,445 | 15% ▲ | 306% | 1,918 | 7% ▼ | -33% |
| **Сингапур** | 1,088 | 2% ▲ | 52% | 726 | 2% ▼ | -38% |
| **Швейцарь** | 1,422 | 2% ▲ | 10% | 149 | 1% ▲ | 63% |
| **Герман** | 1,742 | 3% ▲ | 48% | 595 | 2% ▲ | 22% |
| **Япон** | 1,001 | 1% ▼ | -5% | 643 | 2% ▲ | 12% |
| **Бусад** | 18,061 | 26% ▲ | 80% | 15,117 | 52% ▲ | 20% |
| **НИЙТ** | **68,921** | **100%** | | **29,306** | **100%** | |

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2019 оны 4 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 976 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 202 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 774 сая ам.долларын орох урсгалтай байв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 119 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь харвал:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 206 сая ам.доллараар өсч, 714 сая ам.доллар,
- Люксембург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 64 сая ам.доллараар өсч, 64 сая ам.доллар, харин
- Япон улсаас ирсэн хөрөнгө оруулалт 105 сая ам.доллараар буурч, 20 сая ам.доллар,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 65 сая ам.доллараар буурч, 36 сая ам.долларын орох урсгалтай байсан байна.

*Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)*

| № | Үзүүлэлт | 2019 | | 2019.IV/18.IV | |
|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Хувь | Өөрчлөлт | |
| 1 | Австрали | 4 | 0% | 0 | ▲ |
| 2 | Америк | 8 | 1% | -29 | ▼ |
| 3 | Англи | 17 | 2% | 16 | ▲ |
| 4 | БНХАУ | 36 | 4% | -65 | ▼ |
| 5 | Герман | 1 | 0% | -1 | ▼ |
| 6 | Нидерланд | 4 | 0% | 4 | ▲ |
| 7 | Хонг-Конг | 15 | 2% | 6 | ▲ |
| 8 | Канад | 714 | 73% | 206 | ▲ |
| 9 | Люксембург | 64 | 7% | 64 | ▲ |
| 10 | ОХУ | 4 | 0% | -8 | ▼ |
| 11 | Сингапур | 70 | 7% | 38 | ▲ |
| 12 | Солонгос (өмнөд) | 7 | 1% | 0 | ▼ |
| 13 | Турк | 0 | 0% | 0 | ▼ |
| 14 | Франц | 2 | 0% | -3 | ▼ |
| 15 | Япон | 20 | 2% | -105 | ▼ |
| 16 | Бусад | 12 | 1% | -3 | ▼ |
| | **Нийт** | **976** | **100%** | **119** | ▲ |

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 211 сая ам.доллараар,
- Мэргэжлийн, шинжлэх ухаан болон технологийн үйл ажиллагааны салбар 19 сая ам.доллараар,
- Барилгын салбар 14 сая ам.доллараар тус тус өссөн бол,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 66 сая ам.доллараар,
- Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагааны салбар 49 сая ам.доллараар,
- Боловсруулах үйлдвэрлэлийн салбар 26 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)*

| № | Эдийн засгийн салбар | IV улирал | | 2019.IV/18.IV | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018 | 2019 | Өөрчлөлт | |
| 1 | Барилга | 4 | 18 | 14 | ▲ |
| 2 | Боловсрол | 0 | 0 | 0 | ▲ |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 34 | 8 | -26 | ▼ |
| 4 | Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 87 | 37 | -49 | ▼ |
| 5 | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 0 | 0 | 0 | ▲ |
| 6 | Мэдээлэл, холбоо | 1 | 3 | 2 | ▲ |
| 7 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 3 | 21 | 19 | ▲ |
| 8 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 98 | 33 | -66 | ▼ |
| 9 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 0 | 8 | 8 | ▲ |
| 10 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл | 5 | 10 | 5 | ▲ |
| 11 | Уул уурхай, олборлолт | 606 | 817 | 211 | ▲ |
| 12 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 11 | 13 | 2 | ▲ |
| 13 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 5 | 7 | 2 | ▲ |
| 14 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан | 1 | 0 | -1 | ▼ |
| 15 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 0 | 0 | 0 | ▲ |
| 16 | Бусад | 2 | 0 | -2 | ▼ |
| | **Нийт** | **858** | **976** | **119** | ▲ |

### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2019 оны 4 дүгээр улиралд 30 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиг 479 сая ам.доллараар буурсан.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Мазаалай бондын хүүгийн төлбөрт 27 сая ам.доллар,
- Чингис1000 бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.доллар,
- Гэрэгэ бондын хүүгийн төлбөрт 23 сая ам.доллар,
- Хөгжлийн банк500 бондын хүүгийн төлбөрт 21 сая ам.долларыг эдийн засгийн харьяат бус тус тус төлсөн байна.

*Дүрслэл 9. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)*




### Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд өмнөх санхүүгийн дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд, үүнд, арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүд, худалдааны зээллэг зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг. 2019 оны 4 дүгээр улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 157 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал, 78 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм. Энэ өөрчлөлтөд арилжааны банкуудын харилцах хадгаламжийн данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.

*Дүрслэл 10. Бусад хөрөнгө оруулалт*




## 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2019 оны 4 дүгээр улиралд цэвэр дүнгээр 35,707 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 7,076 сая ам.доллар байна. Үүний 61%-ийг гадаад валютын албан нөөц, 26%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 42,783 сая ам.долларт хүрчээ. Үүний 52%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 35%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 6%-иар буюу 2,077 сая ам.доллараар өссөн байна.

Үүнийг ерөнхий бүтцээр авч үзвэл: гадаад актив 15%-иар буюу 920 сая ам.доллараар, гадаад пассив 8%-иар буюу 2,997 сая ам.доллараар тус тус өссөн.

Харин дансаар нь авч үзвэл: гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 1,999 сая ам.доллар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 596 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 296 сая ам.доллар, албан нөөц 800 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Позицийн нийт өөрчлөлтийг ав үзвэл: төлбөрийн тэнцлийн урсгалаар –1,922 сая

ам.доллар, ханшийн өөрчлөлтөөр 230 сая ам.доллар, бусад өөрчлөлтөөр -163 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 14 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

*Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)*

| Үзүүлэлт | 12/31/2019 | 12/31/2019 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | | | *дүн* | *хувь* |
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-33,630** | **-35,707** | **2,077** | **6%** |
| **I. Гадаад актив** | **6,156** | **7,076** | **920** | 15% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 533 | 623 | 90 | 17% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 297 | 292 | -05 | -2% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 00 | 14 | 14 | 1435x |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 1,784 | 1,806 | 22 | 1% |
| 5. Нөөц актив | 3,542 | 4,341 | 800 | 23% |
| **II. Гадаад пассив** | **39,786** | **42,783** | **2,997** | **8%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 20,223 | 22,312 | 2,089 | 10% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 4,887 | 5,478 | 591 | 12% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 01 | 00 | -01 | -100% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 14,675 | 14,993 | 318 | 2% |

*Дүрслэл 11. Гадаад актив, пассив (сая ам.доллар)*




## Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 11,978 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 10,334 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 7,825 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 35%,
- БНХАУ-аас 4,840 сая ам.доллар буюу 22%,
- Сингапур улсаас 1,640 сая ам.доллар буюу 7%,
- Люксембург улсаас 1,425 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-ийг тус тус бүрдүүлж байна.

*Дүрслэл 12. Шууд шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, 2019 он*




## Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2019 оны 4 дүгээр улиралд 292 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2%-аар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 5,478 сая ам.долларт хүрч, 12%-аар өссөн үзүүлэлттэй байна.

**Актив:** манай эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл: Хонг-Конг 33%, АНУ 18%, Сингапур 12%, Австрали 8%, Их Британ 7%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Монголын эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал: АНУ 22%, Их Британ 9%, Люксембург 6%, Сингапур 3%, Герман 3%, үлдсэн 39% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.

*Дүрслэл 13. Багцын ХО-ын үлдэгдэл, 2019 он*




## 3. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 30,678 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,963 сая ам.доллараар өссөн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 518 сая ам.доллараар өсч 7,702 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 46 сая ам.доллараар буурч, 1,985 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,491 сая ам.доллараар өсч, 20,991 сая ам.долларт хүрээд байна.

*Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар).*

| Үзүүлэлт | 12/31/2018 | 12/31/2019 | өөрчлөлт | | * % |
|---|---|---|---|---|---|
| | | | *дүн* | *хувь* | |
| **Нийт гадаад өр** | **28,715** | **30,678** | **1,963** | **7%** | **100%** |
| **I. Засгийн газар** | **7,184** | **7,702** | **518** | **7%** | **25%** |
| Бонд, өрийн бичиг | 2,946 | 3,123 | 177 | 6% | |
| Зээл | 4,238 | 4,578 | 340 | 8% | |
| **II. Төв банк** | **2,030** | **1,985** | **-46** | **-2%** | **6%** |
| **III. Банк** | **2,230** | **2,140** | **-90** | **-4%** | **7%** |
| Богино хугацаат | 764 | 612 | -152 | -20% | 2% |
| Урт хугацаат | 1,466 | 1,528 | 62 | 4% | 5% |
| **IV. Бусад сектор** | **8,042** | **8,517** | **476** | **6%** | **28%** |
| Богино хугацаат | 609 | 631 | 22 | 4% | 2% |
| Урт хугацаат | 7,433 | 7,887 | 454 | 6% | 26% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **9,228** | **10,334** | **1,106** | **12%** | **34%** |

**: Нийт өсөлтөд оруулсан хувь*

### Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2019 оны 4 дүгээр улирлын эцэст 2,140 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 90 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 43%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 13%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 919 сая ам.доллар, 288 сая ам.долларт хүрэв.

*Дүрслэл 14. Банкны салбарын гадаад өр (сая ам.доллар)*




### Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2019 оны 4 дүгээр улирлын эцэст 18,851 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,581 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 55% буюу 10,334 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн

гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа, төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 380 сая ам.доллар болсон байна.

*Дүрслэл 15. Бусад салбарын гадаад өр (сая ам.доллар)*




*Мэдээллийн эх сурвалж:*

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

## ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

| Үзүүлэлт | IV улирал | | | Өөрчлөлт | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | Дүн | 2018/17 | Дүн | 2019/18 |
| **I. УРСГАЛ ДАНС** | **-590** | **-820** | **-835** | **-230** | **-39%** | **-14** | **-2%** |
| **Бараа ба үйлчилгээний худалдаа** | **-118** | **-537** | **-469** | **-419** | **-354%** | **68** | **13%** |
| **Кредит** | **1,721** | **1,847** | **1,846** | **126** | **7%** | **-1** | **0%** |
| **Дебет** | **1,839** | **2,384** | **2,315** | **545** | **30%** | **-69** | **-3%** |
| **1. Бараа** | **322** | **97** | **29** | **-224** | **-70%** | **-68** | **-70%** |
| 1.1 Экспорт Ф.О.Б (кредит) | 1,521 | 1,622 | 1,554 | 101 | 7% | -68 | -4% |
| 1.2 Импорт Ф.О.Б (дебит) | 1,200 | 1,525 | 1,525 | 325 | 27% | 0 | 0% |
| **2. Үйлчилгээ** | **-440** | **-635** | **-499** | **-195** | **-44%** | **136** | **21%** |
| Кредит | 199 | 224 | 292 | 25 | 12% | 67 | 30% |
| Дебет | 639 | 859 | 790 | 220 | 34% | -68 | -8% |
| 2.1 Тээвэр | -79 | -161 | -98 | -81 | -102% | 63 | 39% |
| Кредит | 80 | 81 | 115 | 1 | 1% | 34 | 42% |
| Дебит | 159 | 241 | 213 | 82 | 52% | -29 | -12% |
| 2.2 Аялал | -85 | -151 | -190 | -66 | -77% | -39 | -26% |
| Кредит | 54 | 61 | 66 | 7 | 12% | 5 | 8% |
| Дебит | 140 | 212 | 256 | 72 | 52% | 44 | 21% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -275 | -323 | -211 | -48 | -17% | 112 | 35% |
| Кредит | 65 | 82 | 111 | 17 | 26% | 28 | 34% |
| Дебит | 340 | 405 | 322 | 65 | 19% | -84 | -21% |
| **3 Анхдагч орлого** | **-523** | **-353** | **-415** | **170** | **32%** | **-62** | **-17%** |
| Кредит | 19 | 88 | 109 | 69 | 364% | 21 | 24% |
| Дебет | 542 | 441 | 524 | -101 | -19% | 82 | 19% |
| 3.1 Ажилчдын цалин | -11 | 46 | 66 | 57 | 528% | 20 | 44% |
| 3.2 Хөрөнгө оруулалтын орлого | -515 | -402 | -492 | 114 | 22% | -90 | -22% |
| 3.3 Бусад | 3 | 2 | 11 | -1 | -18% | 9 | 358% |
| **4 Хоёрдогч орлого** | **52** | **70** | **50** | **19** | **36%** | **-21** | **-29%** |
| Кредит | 73 | 101 | 82 | 28 | 38% | -18 | -18% |
| Дебит | 21 | 30 | 33 | 9 | 43% | 3 | 8% |
| Үүнээс: Хувийн гуйвуулга | 7 | 18 | 4 | 10 | 139% | -14 | -76% |
| **II. ХӨРӨНГИЙН ДАНС** | **21** | **29** | **46** | **8** | **39%** | **17** | **59%** |
| **1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт** | **0** | **0** | **0** | **0** | | **0** | |
| Кредит | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| Дебет | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **2. Хөрөнгийн шилжүүлэг** | **21** | **29** | **46** | **8** | **39%** | **17** | **59%** |
| Кредит | 22 | 29 | 47 | 7 | 33% | 17 | 58% |
| Дебет | 1 | 0 | 0 | -1 | -75% | 0 | -28% |
| **Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-569** | **-791** | **-788** | **-222** | **-39%** | **3** | **0%** |
| **III. САНХҮҮГИЙН ДАНС** | **-1,683** | **-1,024** | **-1,052** | **659** | **39%** | **-28** | **-3%** |
| **Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-1,683** | **-1,024** | **-1,052** | **659** | **39%** | **-28** | **-3%** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | **-474** | **-660** | **-731** | **-186** | **-39%** | **-71** | **-11%** |
| 1.1 Актив | 17 | 6 | 43 | -11 | -66% | 37 | 650% |
| 1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 17 | 9 | 43 | -8 | -49% | 34 | 403% |
| 1.1.2 Өрийн хэрэгсэл | 0 | -3 | 0 | -3 | | 3 | 94% |
| 1.2 Пассив | 491 | 665 | 774 | 175 | 36% | 108 | 16% |
| 1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 358 | 309 | 241 | -49 | -14% | -68 | -22% |
| 1.2.2 Өрийн хэрэгсэл | 133 | 356 | 533 | 223 | 168% | 177 | 50% |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **-395** | **-449** | **30** | **-54** | **-14%** | **479** | **107%** |
| 2.1 Актив | 4 | 8 | 7 | 4 | 103% | -2 | -22% |
| 2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 3 | 18 | 1 | 15 | 448% | -16 | -92% |
| 2.1.2 Өрийн бичиг | 1 | -9 | 5 | -10 | -1149% | 15 | 155% |
| 2.2 Пассив | 399 | 458 | -24 | 58 | 15% | -481 | -105% |
| 2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | -1 | 2 | 1 | 4 | 304% | -1 | -54% |
| 2.2.2 Өрийн бичиг | 401 | 455 | -25 | 55 | 14% | -480 | -105% |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд** | **0** | **0** | **5** | **1** | **221%** | **4** | **1228%** |
| 3.1 Актив | -1 | 0 | 5 | 0 | 48% | 5 | 1617% |
| 3.2 Пассив | 0 | -1 | 0 | 0 | -126% | 1 | 89% |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **-813** | **85** | **-356** | **898** | **110%** | **-441** | **-521%** |
| 4.1 Актив | -327 | 3 | -257 | 330 | 101% | -260 | -9287% |
| 4.1.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах | -327 | 2 | -205 | 329 | 101% | -207 | -10154% |
| 4.1.3 Зээл | 2 | -2 | -14 | -3 | -217% | -12 | -660% |
| 4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -2 | 3 | -38 | 5 | 226% | -41 | -1603% |
| 4.1.5 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2 Пассив | 486 | -82 | 100 | -568 | -117% | 181 | 222% |
| 4.2.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах | -9 | 28 | -6 | 37 | 413% | -34 | -121% |
| 4.2.3 Зээл | 522 | -120 | 83 | -643 | -123% | 203 | 169% |
| 4.2.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд | -11 | -104 | -40 | -93 | -864% | 64 | 62% |
| 4.2.3.3.1 Богино хугацаат | -49 | -29 | 20 | 20 | 41% | 49 | 172% |
| 4.2.3.3.2 Урт хугацаат | 38 | -75 | -60 | -113 | -299% | 15 | 20% |
| 4.2.3.2 Засгийн газар | 581 | 258 | 238 | -323 | -56% | -21 | -8% |
| 4.2.3.4 Бусад салбар | -48 | -275 | -115 | -227 | -477% | 160 | 58% |
| 4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -34 | 10 | 22 | 44 | 130% | 12 | 120% |
| 4.2.6 Бусад авлага | 6 | 0 | 0 | -6 | -100% | 0 | |
| 4.2.7 Зээлжих тусгай эрх | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **IV. Алдаа болон орхигдуулга** | **144** | **101** | **-75** | **-43** | **0** | **-176** | **-2** |
| **V. НӨӨЦ ХӨРӨНГӨ** | **1,258** | **334** | **189** | **-924** | **-73%** | **-145** | **-43%** |
| 1. ГВУН | 1,337 | 370 | 189 | -967 | | -181 | |
| 2. ОУВС-гийн зээл | 79 | 36 | 0 | -43 | | -36 | |
| 3. Тусгай санхүүжилт | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |

** [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.*

**ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2018 | 03/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 | 12/31/2019 |
|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | (33,630) | (34,345) | (34,442) | (34,814) | (35,707) |
| **Актив** | **6,156** | **6,540** | **6,854** | **6,933** | **7,076** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **533** | **545** | **564** | **582** | **623** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **466** | **477** | **496** | **514** | **556** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 466 | 477 | 496 | 514 | 556 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **67** | **68** | **68** | **68** | **68** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 66 | 68 | 67 | 67 | 67 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **297** | **288** | **292** | **289** | **292** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 279 | 271 | 267 | 266 | 263 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 23 | 22 | 23 | 22 | 20 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 256 | 249 | 244 | 244 | 243 |
| Бусад санхүүгийн байгууллага | 210 | 213 | 218 | 219 | 222 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 46 | 36 | 26 | 25 | 21 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 18 | 18 | 25 | 24 | 29 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 7 | 7 | 9 | 6 | 6 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 10 | 10 | 16 | 17 | 22 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 10 | 10 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 6 | 7 | 7 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **3** | **5** | **4** | **14** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 3 | 0 | 0 | 9 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 5 | 4 | 4 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 5 | 4 | 4 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **1,784** | **2,050** | **1,899** | **2,079** | **1,806** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **1,283** | **1,517** | **1,374** | **1,504** | **1,279** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 461 | 806 | 660 | 871 | 582 |
| үүнээс: Банк хоорондын позиц | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 822 | 711 | 714 | 633 | 697 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 822 | 711 | 714 | 633 | 697 |
| **Зээл** | **150** | **156** | **156** | **156** | **146** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 150 | 156 | 156 | 156 | 146 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | (0) | 0 | 1 | 0 | 0 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **352** | **376** | **369** | **419** | **382** |
| **Бусад дансны авлага/өглөг** | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нөөц хөрөнгө** | **3,542** | **3,653** | **4,094** | **3,978** | **4,341** |

| Үзүүлэлт | 12/31/2018 | 03/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 | 12/31/2019 |
|---|---|---|---|---|---|
| **Гадаад пассив** | **39,786** | **40,884** | **41,296** | **41,747** | **42,783** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **20,223** | **20,697** | **21,184** | **21,568** | **22,312** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **10,995** | **11,288** | **11,525** | **11,734** | **11,978** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 10,995 | 11,288 | 11,525 | 11,734 | 11,978 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **9,228** | **9,409** | **9,659** | **9,834** | **10,334** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 9,228 | 9,409 | 9,659 | 9,834 | 10,334 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **4,887** | **5,231** | **5,260** | **5,414** | **5,478** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 75 | 74 | 78 | 79 | 127 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 21 | 21 | 21 | 21 | 21 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 54 | 53 | 57 | 58 | 106 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 4,811 | 5,157 | 5,182 | 5,334 | 5,351 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 624 | 640 | 632 | 628 | 609 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 2,946 | 2,970 | 2,941 | 3,095 | 3,123 |
| Бусад салбарууд | 1,241 | 1,547 | 1,610 | 1,612 | 1,619 |
| Бусад санхүүгийн байгууллага | 787 | 1,102 | 1,099 | 1,121 | 1,116 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 451 | 443 | 60 | 53 | 61 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэглүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **1** | **0** | **0** | **0** | **0** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 1 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **14,675** | **14,956** | **14,852** | **14,765** | **14,993** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **2,123** | **2,199** | **2,086** | **2,015** | **2,041** |
| Төв банк | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 | 1,717 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 327 | 402 | 339 | 332 | 324 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 51 | 11 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллага | 51 | 11 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **12,265** | **12,389** | **12,369** | **12,375** | **12,552** |
| Төв банк | 286 | 287 | 286 | 265 | 268 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 1,279 | 1,352 | 1,274 | 1,250 | 1,207 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 4,238 | 4,293 | 4,306 | 4,279 | 4,578 |
| Бусад салбарууд | 6,462 | 6,458 | 6,503 | 6,582 | 6,499 |
| Бусад санхүүгийн байгууллага | 292 | 300 | 331 | 424 | 435 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 6,170 | 6,158 | 6,172 | 6,158 | 6,064 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **288** | **368** | **396** | **375** | **400** |
| **Бусад дансны авлага/өглөг** | **0** | **0** | **0** | **0** | **0** |

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 12/31/2015 | 12/31/2016 | 12/31/2017 | 12/31/2018 | 3/31/2019 | 6/30/2019 | 9/30/2019 | 12/31/2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Засгийн газар** | **3,759.86** | **4,869** | **7,321** | **7,184** | **7,262** | **7,246** | **7,374** | **7,702** |
| **Богино хугацаат** | - | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 3,760 | 4,869 | 7,321 | 7,184 | 7,262 | 7,246 | 7,374 | 7,702 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | - | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 1,473 | 2,064 | 3,549 | 2,946 | 2,970 | 2,941 | 3,095 | 3,123 |
| Зээл | 2,287 | 2,805 | 3,772 | 4,238 | 4,293 | 4,306 | 4,279 | 4,578 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Төвбанк** | **1,959.64** | **1,791** | **2,025** | **2,030** | **2,072** | **2,034** | **1,948** | **1,985** |
| **Богино хугацаат** | 1,892 | 1,725 | 1,837 | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 | 1,717 |
| Харилцах, хадгаламж 5/ | 1,772 | 1,725 | 1,837 | 1,745 | 1,786 | 1,747 | 1,683 | 1,717 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | 120 | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 68 | 65 | 188 | 286 | 287 | 286 | 265 | 268 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | 68 | 65 | 188 | 286 | 287 | 286 | 265 | 268 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)** | **2,128.50** | **2,417** | **2,194** | **2,230** | **2,393** | **2,245** | **2,209** | **2,140** |
| **Богино хугацаат** | 407 | 469 | 659 | 764 | 780 | 722 | 680 | 612 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | 314 | 327 | 402 | 339 | 332 | 324 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - | - |
| Зээл | 407 | 469 | 345 | 437 | 378 | 383 | 348 | 288 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 1,721 | 1,948 | 1,535 | 1,466 | 1,613 | 1,523 | 1,529 | 1,528 |
| Харилцах, хадгаламж 5/ | 182 | 240 | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 652 | 611 | 589 | 624 | 640 | 632 | 628 | 609 |
| Зээл | 887 | 1,098 | 946 | 842 | 973 | 891 | 902 | 919 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Бусад салбарууд** | **3,748.95** | **8,121** | **7,956** | **8,042** | **8,385** | **8,509** | **8,569** | **8,517** |
| **Богино хугацаат** | 326 | 394 | 666 | 609 | 630 | 662 | 622 | 631 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | 95 | 51 | 11 | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| Зээл | 260 | 218 | 292 | 275 | 269 | 284 | 265 | 249 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 64 | 175 | 277 | 281 | 347 | 376 | 355 | 380 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 3,423 | 7,727 | 7,289 | 7,433 | 7,755 | 7,847 | 7,947 | 7,887 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 860 | 884 | 726 | 1,239 | 1,545 | 1,607 | 1,610 | 1,616 |
| Зээл | 2,489 | 6,802 | 6,560 | 6,187 | 6,189 | 6,219 | 6,317 | 6,250 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 74 | 41 | 3 | 7 | 20 | 20 | 20 | 20 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - | - |
| **Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг** | **11,120.86** | **7,426** | **7,996** | **9,228** | **9,409** | **9,659** | **9,834** | **10,334** |
| Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг | 11,121 | 7,426 | 7,996 | 9,228 | 9,409 | 9,659 | 9,834 | 10,334 |
| Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг | - | - | - | - | - | - | - | - |
| Хамааралтай компани хоорондын өглөг | - | - | - | - | - | - | - | - |
| **Нийт гадаад өр** | **22,717.82** | **24,625** | **27,493** | **28,715** | **29,522** | **29,693** | **29,934** | **30,678** |